



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР



World Health
Organization

Representative Office
for Mongolia

“ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ” ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА

УЛААНБААТАР ХОТ
2022 он

Эрхэлсэн: Х.Улам-Өрнөх
Д.Нарантуяа

ТХААГ-ын дарга
ЭЭХХЗГ-ын дарга

Редактор: Н.Цэрэнсамбуу
Г.Цэцэнсанаа

ТХААГ-ын ЦХААМТХ-ийн дарга
ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын дарга

Эмхэтгэсэн:
Б.Чойсүрэн
Г.Хулан

ТХААГ-ын ЦХААМТХ-ийн мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын мэргэжилтэн

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:
Н.Мөнхзаяа

ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын мэргэжилтэн

Төрийн худалдан авах ажиллагааны газар:


Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-16, Засгийн газрын IX байр

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, УВН төв, 8 давхар

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж-2, Засгийн газрын VIII байр, Эрүүл мэндийн яам



“ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ” ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

**УЛААНБААТАР ХОТ
2022 он**

ЦАХИМ СИСТЕМИЙН ТУХАЙ /www.tender.gov.mn/

Монгол Улсын Засгийн газраас худалдан авах ажиллагааны үйл явцыг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийг боловсруулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер шалгаруулалт зохион байгуулах, гэрээ, гэрээний гүйцэтгэлийг удирдах, тендер шалгаруулалтад оролцох, цахим шалгалтыг зохион байгуулах, ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах болон төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн мэдээлэл солилцооны цахим тогтолцоог бий болгохоор уг системийг хөгжүүлсэн.

ЦАХИМ СИСТЕМИЙН ЗОРИЛГО

Энэхүү системийн зорилго нь улсын болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг цахим орчинд нэгдсэн нэг удирдлага, хяналтын дор ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

ЦАХИМ СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжоор зохицуулагдана.

Холбогдох журмууд:

- Босго үнэ шинэчлэн батлах тухай
- Бүртгэл хөтлөх журам
- Ерөнхий гэрээ байгуулах журам
- Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам
- Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам
- Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам
- Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам
- Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам
- Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам

- Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам
- Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам


МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ САЛБАРТ ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛСЭН ТҮҮХЭН ТОВЧООН



Зураг 1. Худалдан авах ажиллагааны цахим системийн хөгжлийн үе шат

БҮРЭЛДЭХҮҮН ДЭД СИСТЕМҮҮД

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ



Зураг 2. Худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн дэд системүүд

ЦАХИМ ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМ /www.tender.gov.mn/eshop/

Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрийн систем нь төрийн байгууллагуудын урсгал зардлаар зохион байгуулагддаг байнгын хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээг нэг буюу түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчээс худалдан авах боломжийг бүрдүүлсэн систем юм. Тус системийн үйл ажиллагааг Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”-аар тусгайлан зохицуулдаг бөгөөд өөрөөр “Ерөнхий гэрээний систем” ч гэж нэрлэж болно. Ерөнхий гэрээгээр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажлыг 2018 оноос эхлэн зохион байгуулж эхэлсэн.



Зураг 3. Цахим дэлгүүрийн системийн бүрэлдэхүүн

ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

- Төрийн байгууллагууд нэг ижил үнээр, ижил чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах боломж бүрдүүлэх;
- Захиалагч нь нийлүүлэгч болон тухайн бараа, ажил, үйлчилгээнд үнэлгээ өгөх;
- Төрийн байгууллагуудын байнгын хэрэгцээтэй бараа үйлчилгээний судалгааг хийх;
- Байнгын хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээний цахим ангилал болон түүний хувийн шинж чанарын нэгдсэн сантай болох;
- Худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээний үнэ, тоо хэмжээнд үндэслэн нэгдсэн бодит тоо мэдээ гарган авах, төлөвлөлт хийх;



Зураг 4. Цахим дэлгүүрийн системийн процесс


ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ, БҮТЭЦ



Зураг 5. Захиалагч байгууллагын ангилал

1. ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БА ЦАХИМ ДЭЛГҮҮР

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлд:



5.1.23-т ЕРӨНХИЙ ГЭРЭЭ гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг хэлнэ;



5.1.27-т ЦАХИМ ДЭЛГҮҮР гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зохиулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд:



8.13-т ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ДАГУУ цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно гэж тус тус заасан байдаг.

2. ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 234 дүгээр тушаалаар **“ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ”**-ыг баталсан. Уг журам нь дараах бүтэцтэй. Үүнд:

- Нийтлэг үндэслэл
- Ерөнхий гэрээг зохион байгуулах
- Ерөнхий гэрээний нэгдүгээр шатны шалгаруулалтын зохион байгуулалт
- Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын зохион байгуулалт
- Шууд сонголтын арга
- Цахим үнэ хаялцуулах арга
- Үнийн санал авах арга
- Мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг
- Захиалагчийн эрх, үүрэг
- Ерөнхий гэрээг өөрчлөх, цуцлах үндэслэл
- Маягт: Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний судалгаа


2.1 Ерөнхий гэрээг зохион байгуулах

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.5.7-т заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Ерөнхий гэрээ байгуулах нэгж үнэ нь татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг багтаасан байх бөгөөд цахим дэлгүүрт байршуулахдаа “нэгж үнэ”, “тээвэрлэлтийн зардлыг хассан нэгж үнэ” гэсэн сонголттойгоор оруулна.

Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд гэрээнд өөрчлөлт оруулах нөхцөл үүссэн бол ерөнхий гэрээний талууд харилцан зөвшөөрсний дагуу гэрээнд өөрчлөлт оруулж болно.





Зураг 6. Ерөнхий гэрээний үе шатны схем

- Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд түүний шалгуур, шаардлагыг хангасан аливаа нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн хувьд Ерөнхий гэрээ байгуулах эрх нээлттэй байна. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн тоог хязгаарлахгүй.
- Захиалагч ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээ худалдан авахдаа зөвхөн цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй энэ журам болон ерөнхий гэрээний нөхцөл, шаардлагын дагуу гэрээ байгуулж, худалдан авна.
- Ерөнхий гэрээг Сангийн сайдын баталсан Ерөнхий гэрээний жишиг баримт бичигт тусгагдсан гэрээний нөхцөлөөр байгуулна.
- Ерөнхий гэрээнд тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааг банкны баталгааны хэлбэрээр шаардахгүй бөгөөд тендерт оролцогч уг баталгааг Ерөнхий гэрээний жишиг баримт бичигт заасан мэдэгдэл хэлбэрээр ирүүлнэ. Мэдэгдлийг ирүүлээгүй нь тендерт оролцогчийн тендерээс татгалзах, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг цуцлах үндэслэл болно.

2.2 Ерөнхий гэрээний нэгдүгээр шатны шалгаруулалт зохион байгуулах

Нэгдүгээр шат: Мэргэжлийн байгууллага захиалагчийн худалдан авах бараа, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, ерөнхий гэрээ байгуулан, шалгарсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг бараа, үйлчилгээний мэдээлэл бүхий цахим худалдан авах ажиллагааны системийн бүрэлдэхүүн хэсэг болох “Цахим дэлгүүр” –т бүртгэнэ.

Ерөнхий гэрээний тендерийн баримт бичиг

Тендерийн баримт бичигт дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Техникийн тодорхойлолт;
- Ажлын даалгавар;
- Шалгуур үзүүлэлт;
- Худалдан авалтын захиалга;
- Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний судалгаа багтана.


Ерөнхий гэрээний тендер шалгаруулалтын урилга

Тендер шалгаруулалтын урилгад хуульд заасан мэдээллээс гадна дараах нэмэлт мэдээллийг тусгана. Үүнд:

- Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын арга;
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаа;
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд тендер шалгаруулалтын шаардлагыг хангасан тохиолдолд шинээр нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй ерөнхий гэрээ байгуулах эрх нээлттэй байх тухай мэдээллүүд багтана.

Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний судалгаа

Мэргэжлийн байгууллага нь ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээг тодорхойлохдоо Зураг 7-д заасан судалгаануудыг хийж, түүний үр дүнд үндэслэн саналаа нэгтгэн боловсруулж, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



Зураг 7. Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний судалгаа

Ерөнхий гэрээнд тусгах зүйлс

Гэрээнд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Худалдан авч болох барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгавар;
- Хүчинтэй хугацаанд худалдан авах боломжтой бараа, үйлчилгээний нийт тооцоолсон өртөг;
- Худалдан авах бараа, үйлчилгээний нэгжийн үнэ;
- Худалдан авах бараа, үйлчилгээний нэр төрөл, багцлалт;
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаа;
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд “Цахим дэлгүүр”-ээс бараа, үйлчилгээг худалдан авах II шатны шалгаруулалтын арга;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Гэрээний тусгай нөхцөл болон Мэргэжлийн байгууллага, захиалагчийн бусад шаардлага;
- Ерөнхий гэрээ байгуулах, тус гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулах эрхийг олгох тухай мэдээлэл;
- Тодорхой тохиолдолд: Ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ болон хүргэх газрын мэдээллүүд багтана.

Ерөнхий гэрээний тендер шалгаруулалтын үнэлгээ

Тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийг үнэлэхдээ хуульд заасан хянан үзэх үе шатны үнэлгээг хийж, шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн бүх тендерийг дараах зарчмын дагуу үнэлнэ. Үүнд:

- Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг тухайн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн Мэргэжлийн байгууллагын тогтоосон босго нэгж үнийн дээд хязгаартай харьцуулан үнэлнэ.
- Тендерт оролцогчийн ирүүлсэн үнэ нь дээрх үнэтэй тэнцүү буюу түүнээс бага үнийн санал ирүүлсэн бол шаардлагад нийцсэн гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгоно. Харин их үнийн санал ирүүлсэн бол шаардлагад нийцээгүй гэж татгалзана.

Тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцохоор заасан бол түүнийг үнэлгээнд харгалзана.

Ерөнхий гэрээний тендер шалгаруулалтын үр дүн

Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага шаардлагад нийцсэн оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох эсхүл татгалзсан тохиолдолд хуульд заасан шаардлагын дагуу мэдэгдлийг хүргүүлж, шалгарсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчидтэй Ерөнхий гэрээ байгуулж, гэрээний хамрах хүрээгээр эсхүл бараа, ажил, үйлчилгээний төрлөөр ангилан,

цахим дэлгүүрт гэрээ байгуулсан өдөрт багтаан байршуулна.

Мэргэжлийн байгууллага тендер шалгаруулалтын үнэлгээний дараах мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулна. Үүнд:

- Тендерт оролцогчийн нэр, ирүүлсэн үнийн санал;
- Гэрээ байгуулах эрх олгогдсон тендерт оролцогчийн жагсаалт;
- Худалдан авах барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгавартай нийцсэн эсэх талаарх дүгнэлт;
- Татгалзсан болон шаардлага хангаагүй тендерт оролцогчийн жагсаалт, татгалзсан үндэслэл;
- Тендерийн үнэлгээний хураангуй дүгнэлт багтана.

Цахим дэлгүүрт бараа, үйлчилгээ бүртгэх

- Мэргэжлийн байгууллага шалгарсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчидтэй Ерөнхий гэрээ байгуулж, гэрээний хамрах хүрээгээр эсхүл бараа, ажил, үйлчилгээний төрлөөр ангилан, цахим дэлгүүрт гэрээ байгуулсан өдөрт багтаан байршуулна.
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд шинээр ерөнхий гэрээ байгуулах хүсэлтэй хуулийн этгээд Мэргэжлийн байгууллагад бичгээр хүсэлтээ ирүүлнэ.
- Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд шаардлагатай гэж үзвэл ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг жилд 2 буюу түүнээс дээш удаа зохион байгуулж болно.
- Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд шинээр ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа анх зарласан тендерийн баримт бичгийн дагуу явуулах бөгөөд тендер шалгаруулалтын шаардлагыг нэмэгдүүлэх эсхүл багасгахыг хориглоно.
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд гэрээ шинээр байгуулсан оролцогчийн гэрээний хугацаа нь тухайн ерөнхий гэрээний үлдсэн хугацаагаар байгуулагдах бөгөөд гэрээний эрх, үүрэг мөн адил байна.
- Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь чадварын шаардлагыг цаашид хангаж чадахгүй болсон бол энэ тухайгаа мэргэжлийн байгууллагад нэн даруй буюу өөрчлөлт гарснаас хойш 7 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

2.3 Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалт зохион байгуулах

Хоёрдугаар шат: Хуульд заасан захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн бараа, үйлчилгээнээс худалдан авахдаа “**Шууд сонголт**”, “**Цахим үнэ хаялцуулах**”, “**Үнийн санал авах**” аргуудын аль тохирохыг сонгон цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй тухайн бараа, үйлчилгээг худалдан авахаар хэлэлцэн, тохиролцож “Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ” байгуулна.

Ерөнхий гэрээний дагуу хийгдэх худалдан авах гэрээ Шууд сонголтын арга, Цахим үнэ хаялцуулах арга, Үнийн санал авах аргуудын аль тохироход үндэслэн ерөнхий гэрээний нөхцөл шаардлагын дагуу хийгдэнэ. Захиалга хийхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Захиалагч цахим дэлгүүрээс худалдан авалт хийх бүрд захиалгын хуудсыг цахим системд ирүүлнэ.
- Захиалагчаас ирүүлсэн захиалгын хуудас хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан II шатны шалгаруулалтыг зохион байгуулна
- Хоёрдугаар шатны шалгаруулалтын үед захиалагч барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгаварт өөрчлөлт оруулахыг хориглоно.
- Цахим үнэ хаялцуулах, Үнийн санал авах ажиллагаанд санал ирээгүй бол захиалагч шууд сонголтын аргыг ашиглан гэрээ байгуулна.
- Хоёрдугаар шатны шалгаруулалтын үр дүнд гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч гэрээнд зааснаас өөр эсхүл чанарын болон иж бүрдлийн доголдолтой бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн бол захиалагч энэ талаар мэргэжлийн байгууллага болон нийлүүлэгчид нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.
- Мэдэгдэлд дурдсан хугацаанд нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь дутагдлыг залруулаагүй тохиолдолд захиалагч нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бусад нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээс тухайн барааг шууд сонголтын аргаар худалдан авна.



Хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцоогүй, эсхүл энэ журам болон гэрээнд заасан нөхцөлийн улмаас нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ерөнхий гэрээг цуцлагдаж, цахим дэлгүүр дэх нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн тоо нэгээс доош буурсан бол мэргэжлийн байгууллага тухайн ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулж, ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацааны үлдсэн хугацаагаар шинэ нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулна.

ЦАХИМ ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ АРГА



- Худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийг бууруулах зорилгоор цахим үнэ хаялцуулах аргыг хэрэглэнэ.
- Цахим үнэ хаялцуулах ажиллагаанд оролцох урилгыг тухайн ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчид цахим систем, бүртгэгдсэн цахим шуудангийн хаягаар хүргүүлж, тухайн өдрөөс хойш ажлын 3 хүртэл хоногийн дараа цахим үнэ хаялцуулах

ажиллагааг 2 цаг хүртэл хугацаагаар зохион байгуулна.

- Цахим үнэ хаялцуулах ажиллагаанд хамгийн бага үнийн санал ирүүлсэн оролцогчтой захиалагч гэрээ байгуулна.

ҮНИЙН САНАЛ АВАХ АРГА

- Худалдан авах бараа, үйлчилгээний тухайлсан хүргэх газар, тоо хэмжээ, хамрах хүрээнд үндэслэн эцсийн үнэ авахад үнийн санал авах аргыг хэрэглэнэ.
- Үнийн санал авах ажиллагаанд оролцох урилгыг тухайн ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчид цахим систем, бүртгэгдсэн цахим шуудангийн хаягаар хүргүүлж, үнийн санал авах хугацааг тухайн өдрөөс хойш ажлын 5 хүртэл хоногоор тогтооно.
- Үнийн санал авах ажиллагаанд үнэ, ажлын хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, хүргэлтийн нөхцөл зэргийг харгалзан хамгийн бага үнийн санал ирүүлсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй захиалагч гэрээ байгуулна.



ШУУД СОНГОЛТЫН АРГА

- Цахим дэлгүүрийн санд бүртгэгдсэн бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар нь тодорхой нөхцөлд уг аргыг хэрэглэнэ.
- Цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдээс хамгийн бага үнийн санал бүхий нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон, худалдан авна.

- Цахим үнэ хаялцуулах, Үнийн санал авах ажиллагаанд санал ирээгүй бол захиалагч шууд сонголтын аргыг ашиглан, гэрээ байгуулна.
- Гэрээ байгуулсан этгээд дутагдлыг залруулаагүй тохиолдолд захиалагч нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бусад нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээс тухайн барааг шууд сонголтын аргаар худалдан авна.

2.4 Мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг

Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Захиалагч, нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нарт зориулан Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах гарын авлагыг боловсруулах. Уг гарын авлагад худалдан авалтын захиалгын жишиг маягт, захиалгын хуудсын маягтыг хавсаргана;
- Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний судалгааг энэхүү журмын маягтад заасны дагуу жил бүрийн гуравдугаар улиралд багтаан хийх;
- Тухайн бараа, үйлчилгээний зах зээлийн судалгаанд үндэслэн ерөнхий гэрээний тендер шалгаруулалтын үнэлгээнд харгалзах нэгж босго үнийн дээд хязгаарыг тогтоох;
- Ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, үйлчилгээний стандартчилсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавар мөн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгох шалгуур үзүүлэлтийг 8.1.2 дахь заалтад заасан судалгаанд үндэслэн боловсруулах;
- Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацааг тогтоох;
- Ерөнхий гэрээний журмыг боловсронгуй болгон сайжруулах санал боловсруулж, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- Ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах;
- Ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийх цахим дэлгүүрийг цахим худалдан авах ажиллагааны системд бий болгох, хэвийн ажиллах нөхцөлийг ханган системийг хөгжүүлэх;
- Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим худалдан авах ажиллагааны системийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулах;
- Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, захиалагч байгууллагаас бараа, үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй асуудлаар мэдээлэл ирүүлсэн тохиолдолд тухайн дутагдлыг засуулах, бусад холбогдох арга хэмжээ авах;
- Захиалагч бүрийн худалдан авалтын захиалгын дүн нь ерөнхий

гэрээний дагуу хийсэн худалдан авах гэрээний тоо хэмжээтэй тохирч байгаа эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

- Ерөнхий гэрээний хэрэгжилт болон үр дүнгийн тайланг энэ журмын 8.2 дахь хэсэгт заасан тайланг нэгтгэн улирал бүр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлэх;
- Захиалагч болон тендерт оролцогчийг ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд сургалт зохион байгуулах.
- Бүх тендерээс татгалзсан үндэслэл зэрэг болно.

2.5 Захиалагчийн эрх, үүрэг

Захиалагч ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мэргэжлийн байгууллагаас хийх судалгаанд хэрэгцээт бараа, үйлчилгээний тоо хэмжээг үндэслэлтэй тодорхойлж, техникийн тодорхойлолтын хамт мэргэжлийн байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор хүргүүлэх;
- Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, үйлчилгээний худалдан авалтын захиалгыг бэлтгэж, мэргэжлийн байгууллагад улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор багтаан хүргүүлэх;
- Захиалагч бараа, үйлчилгээг худалдан авахдаа зөвхөн цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй энэ журамд заасны дагуу худалдан авах гэрээ байгуулах;
- Засгийн газрын баталсан Мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх худалдан авах жагсаалтад ерөнхий гэрээ байгуулахаар заасан бараа, үйлчилгээг тендер шалгаруулалтын бусад журмын дагуу худалдан авахгүй байх;
- Худалдан авалтын захиалга хийх бараа, үйлчилгээний төсөвт өртөг батлагдсан эсэхийг шалгасан байх;
- Захиалгын хуудаст заасан тоо хэмжээ нь шаардагдаж буй хэрэгцээг хангаж байгаа эсэхийг нягтлан, баталгаажуулсан байх;
- Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулж, хүлээн авсан бараа, үйлчилгээг чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг шалган, ямар нэгэн доголдол гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэх, цахим дэлгүүртүнэлгээ өгөх, холбогдох төлбөрийг саадгүй гүйцэтгэх;
- Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээний хэрэгжилт болон үр дүнг цахим худалдан авах ажиллагааны системд тухай бүр оруулах.

Захиалагч худалдан авалт хийхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- *Захиалагч нь ерөнхий гэрээний дагуу худалдан авахаар цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг өөр эх сурвалжаас худалдан авахгүй.*
- *Цахим дэлгүүрээс худалдан авалт хийхдээ хоёрдугаар шатны шалгааруулалтын үр дүнд үндэслэн худалдан авах гэрээ байгуулна.*
- *Худалдан авалтын захиалгыг цахим хэлбэрээр Цахим дэлгүүрийн зааврын дагуу хийнэ.*

2.6 Ерөнхий гэрээг өөрчлөх цуцлах үндэслэл

Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд гэрээнд өөрчлөлт оруулах нөхцөл үүссэн бол ерөнхий гэрээний талууд харилцан зөвшөөрсний дагуу гэрээнд өөрчлөлт оруулж болно.

Мэргэжлийн байгууллага нь Ерөнхий гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, хуульд заасан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах нөхцөл үүссэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хүргүүлж, бүртгэлд хамруулна. Бүртгэлд хамрагдсан нь Ерөнхий гэрээ, Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээг цуцлах шууд үндэслэл болно.

Мэргэжлийн байгууллагын шийдвэрээр дараах тохиолдолд гэрээг цуцалж болно. Үүнд:

- Хууль болон гэрээнд заасан гэрээ цуцлах нөхцөл үүссэн бол;
- Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч хоёроос дээш удаа гэрээний үүргээ биелүүлээгүй болон гаргасан алдаа дутагдал давтагдсан бол;
- Захиалагч, нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн хооронд байгуулсан худалдан авах гэрээ цуцлагдсан бол;
- Захиалагч нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй үгсэн хуйвалдсаныг эрх бүхий байгууллага тогтоосон бол.


Захиалагчийн шийдвэрээр дараах тохиолдолд худалдан авах гэрээг цуцалж болно. Үүнд:

- Захиалагчаас заасан хугацаанд нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч дутагдлыг арилгаагүй бол;
- Хууль болон гэрээнд заасан гэрээ цуцлах нөхцөл үүссэн бол.


Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага ноогдуулна.

3.ЦАХИМ ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМ ДЭЭР АЖИЛЛАХ ДАРААЛАЛ

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.user.tender.gov.mn/-ийн нүүр хуудаснаас **ЦАХИМ ДЭЛГҮҮР** цэсээр хандана.




Зураг 8. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн нүүр хуудас



Зураг 9. Цахим дэлгүүрийн систем

АЛХАМ 1. ЗАХИАЛГА ХИЙХ

1. Цахим дэлгүүрийн системийн барааны жагсаалтаас нийлүүлэгч байгууллага, барааны нэр, дээд үнэ, доод үнэ зэрэг талбаруудаар хайлт хийх боломжтой байна.



Зураг 10. Барааны жагсаалтаас хайх

- **БАРААНЫ НЭР** – Барааны нэрийг гараас оруулна
- **НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА** – Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч байгууллагуудаас сонгоно
- **ДЭЭД ҮНЭ** – Дээд үнийн мэдээллийг гараас оруулна
- **ДООД ҮНЭ** – Доод үнийн мэдээллийг гараас оруулна
- **ХАЙХ** – Хайлтын утгуудыг харуулна
- **ЦЭВЭРЛЭХ** – Хайлтын талбаруудад оруулсан утгыг арилгана

2. Барааны карт дээр курсорыг байрлуулахад тухайн барааг “Сагсанд хийх” болон “Түргэн харах” товчнууд байрлана.



Зураг 11. Барааны карт /сагсанд хийх/

Захиалагч барааг сагсанд хийхдээ барааны карт дээр курсорыг байрлуулан “Сагсанд хийх” товчийг дарна эсвэл “Түргэн үзэх” товчийг дарж захиалга хийх товчийг дарснаар тухайн сонгосон сагсанд нэмэгдэнэ.



Эмийн төрөл зүйл

БИСОПРОЛОЛ 10МГ

Ерөнхий гэрээний үнэ:

1,000 ₮

Тоо: + -

Хэмжээ нэгж: Ширхэг

ЗАХИАЛГА НЭМЭХ

Дэлгэрэнгүй:

Үйлдвэрлэгчийн нэр	КВКА
Худалдааны нэршил	Нипертен
Хадгалах нөхцөл	30°C-аас доош хэмд хууцаж хэрэглээгүй газар хадгална.
Эмийн хэлбэр	Шалхал
Хэрэглэх заалт	Даралтыг авчирч бууруулах ба зүрхний цохилтыг ихэсгэхгүй урт хугацааны үйлчилгээтэй
Савлагтын хэмжээ	бүрхүүлтэй шалхал хэлбэрээр 10 ширхгээр тусгай үр бүхий савлагтанд савлагдана.
Эмийн дугаар	бүртгэлийн F20150210CP04294
Нэмэлт мэдээлэл	Словени Улс
Тун хэмжээ	10мг
Овоо уусгах нэршил	Бисопролол

Зураг 12. Барааны дэлгэрэнгүй мэдээлэл

3. Захиалах барааг сагсанд хийхэд дэлгэцийн баруун доод буланд сагсны мэдээлэл байрших ба хэдэн бараа байгаа талаар тоог харуулна.

ХОЛБОО БАРИХ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-210349, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө, Засгийн газрын IX байр, Төрийн худалдан авах ажиллагааны газар

Утас: 7272-0000

И-мэйл: it@procurement.gov.mn


ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ

ХОЛБООС




Зураг 13. Сагсны мэдээлэл

4. Дэлгэцийн баруун доод буланд байрлах сагсан дахь “Барааг харах” товч, “Сагснаас барааг устгах” товч, “Устгасан барааг буцаах” товч, “Захиалга хийх” товч дээр дарж **МИНИЙ ЗАХИАЛГА** хэсэг рүү шилжинэ.



Зураг 14. Сагсан дахь бараатай ажиллах

5. Захиалагчийн админ эрхээр худалдан авах ажиллагааны цахим системд нэвтрэхийн тулд захиалга хийх товчийг дарахад худалдан авах ажиллагааны цахим системд нэвтрэх цонх нээгдэнэ. Захиалагчийн админ эрхийн хэрэглэгчийн нэр нууц үгийг холбогдох талбарт оруулж цахим системд нэвтэрнэ.



Зураг 15. Худалдан авах ажиллагааны цахим системд нэвтрэх цонх

6. Миний захиалга цонхонд худалдан авахаар сонгосон сагсан дахь бараа, үйлчилгээг нийлүүлэхээр ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч тус бүрээр үнийг харуулна. Энэ хэсэгт захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо, ширхэг болон нийлүүлэх хугацаа, барааны дэлгэрэнгүй шинж чанарыг оруулан “Захиалга хийх” товчийг дарна.

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ

Хэрэглэгчийн нэр: /НЭГЭНСЭНБҮҮ (НЭЭГ) Төрийн худалдан авах ажиллагааны газар Гэрээ

БАРААНЫ ЖАГСАЛТ ЗАХИАЛГА БАРААНИЙЛҮҮЛЭГЧ ГЭРЭЭ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

АЛХАМ 1 ЗАХИАЛГЫН НӨДӨӨЗӨЛ АЛХАМ 2 БАТАЛГААЖУУЛАХ АЛХАМ 3 ЗАХИАЛГЫН ЖАГСАЛТ

МИНИЙ ЗАХИАЛГА

№	ЗУРАГ	БАРААНЫ НӨДӨӨЗӨЛ	НИЙЛҮҮЛЭГЧ	ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ҮНЭ	ТОО ХЭМЖЭЭ	НИЙЛҮҮЛЭХ ХУГАЦАА	ШИНЖ ЧАНАР	ХАСАХ
2		БИСОПРОЛОЛ 5МГ Энгийн төрөл хүйт Барааны код: 202203007_29	Монфа трейд	400.00 ₮	1	Бараа нийлүүлэх хугацаа багтаах өдөр 10 хоног байна.	Барааны техникийн тодорхойлолт бичих.	Х
21		БИСОПРОЛОЛ 5МГ Энгийн төрөл хүйт Барааны код: 202203007_29	Алфидна	400 ₮				Х

ЗАХИАЛГА ҮЙНЭ

Зураг 16. Захиалгын мэдээлэл

- **БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ** – Барааны нэр, хамаарах ангиллын нэр, барааны код зэргийг харуулна.
- **НИЙЛҮҮЛЭГЧ** – Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч компаний нэрийг харуулна
- **ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ҮНЭ** – Тухайн нийлүүлэгч компаний ерөнхий гэрээний үнийг харуулна.
- **ТОО ХЭМЖЭЭ** – Тухайн захиалгаар захиалах барааны тоог эцсийн байдлаар нягталж оруулна.
- **НИЙЛҮҮЛЭХ ХУГАЦАА** – Бараа нийлүүлэх хугацааг оруулна.
- **ШИНЖ ЧАНАР** – Барааны техникийн тодорхойлолтыг илүү нарийн зааж өгөх шаардлагатай бол оруулж өгнө.
- **ХАСАХ** – Тус баганы утга дээр дарснаар жагсаалтаас барааг хасна.
- **САГС ХООСЛОХ** – Захиалгын жагсаалт дахь бүх барааг хасна.



Худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрсэн хэрэглэгч **ЗАХИАЛГА ХИЙХ** товч дээр дарвал захиалга баталгаажуулах цонх руу шилжинэ. Харин нэвтрээгүй хэрэглэгч бол нэвтрэх цонх харуулах бөгөөд захиалагчийн эрхээр системд нэвтрэх үйлдлийг хийхэд баталгаажуулах цонх руу шилжих юм.

АЛХАМ 2. ЗАХИАЛГА БАТАЛГААЖУУЛАХ

Захиалгын мэдээллийг сайтар нягтлаад үнийн санал хүлээн авах эцсийн хугацааг оруулж, үйлчилгээний нөхцөлтэй сайтар танилцаад “**Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрч байна**” гэсэн чекбоксыг чеклээд “**Баталгаажуулах**” товч дээр дарснаар захиалга хийгдэнэ.

 АЛХАМ 1
САГСНЫ МЭДЭЭЛЭЛ

>>

 АЛХАМ 2
БАТАЛГААЖУУЛАХ

>>

 АЛХАМ 3
ЗАХИАЛГЫН ЖАГСААЛТ

№	БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ	НИЙЛҮҮЛЭГЧ	ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ҮНЭ	ТОО ХЭМЖЭЭ	НИЙЛҮҮЛЭХ ХУГАЦАА	ЦӨЛӨЖ ЧАНАР
1	Вискороло 10кг Энгийн төрөл	Анфирма		1,000.00 ₮	х1	2022-04-14
2	Вискороло 2.5кг Энгийн төрөл	Монфа трейд		240.00 ₮	х1	2022-04-14
21	Вискороло 2.5кг Энгийн төрөл	Анфирма		240.00 ₮		

ХЭРГЭЛТЭЙН НЭР

Н.Цирсанамбуу

САНАЛ ХҮЛЭЭН АВАХ ОЛГОО

Үнийн санал тухалдаа санал хүлээн авах хэрхэн тухадаа байна.

2-Р ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

Үнийн санал авах арга

ХҮРГЭЛТЭЭР АВАХ ЭСХ

Тайн

БАРЬМТ БИЧИГ ШИЛЖҮҮЛЭХ АРГА

Ангуул

ОНЛАЙН САЛБАРЫН ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ЦАХИМ ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМ ГЭЖ ХҮВ ВЭ?

Энэхүү системийн зориото нь Сангийн сайдын 2017 оны 07 сарын 04-ний өдрийн 134 дүгээр тушаалын хавсгалтаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журмын” чин хэрэгжлийн хангамж өршино.

“ЦАХИМ ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМ”-ийн үйлчилгээний нөхцөл

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. “Цахим дэлгүүрийн систем” нь “Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн нэг дэд систем бөгөөд янз бүр системийг ашигласнаар та нэвчл цахим системийн Үйлчилгээний нөхцөл дор бичигдсэнгүй зөвшөөрч байгаагаар илэрхийлж байгаа юм. “Ерөнхий гэрээ байгуулах журмын”-ын 1.2-т заасан байгууллага нь тэдгэрийг нөхцөл тодоролд ямар ч цахим системийн Үйлчилгээний нөхцөл ашигласнаар оруулж эрхтэй. Та цахим системээр дамжин үйл ажиллагаа явуулах бүрэлд бичиж, мөхөөдүгээр төмөрлөг юу.
2. Сангийн сайдын 2017 оны 07 сарын 04-ний өдрийн 134 дүгээр тушаалын хавсгалтаар батлагдсан “Ерөнхий гэрээний байгууллах журмын”-ын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бариг, өмч, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 4.5-т заасан Захиалагч байгууллагууд байнгын хэрэгцээг бариг, өмч, үйлчилгээний худалдан авах явцуу цахим системийг ашиглана.
3. Энэхүү үйлчилгээний нөхцөл тодоролд бүсэд хэрэгцээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бариг, өмч, үйлчилгээний худалдан авах тухай хууль, Ерөнхий гэрээ байгуулах журмын болон хуулийн 2.1-т заасан тэдгэрийг нөхцөл тодоролд хууль тогтоомжийн бүсэд өнгөрөж буйг, өмчөөр зогсоулна.
4. Хууль, түүнийг дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бариг, өмч, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөө / цахимд Төрийн байгууллага өмч болон цахим системийг хэрэглэн / захиалагч болон нийлүүлэгч байгууллагууд санхүүг амнагт авна.

ЦАХИМ СИСТЕМ ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРЭЭ


1. Захиалагч бариг, өмчөөр үйлчилгээний нөхцөл тодоролд нийлүүлэгч байгууллагатай уламжлалт салбарын байгууллага, төрөөний нэгдлийн цахим системд бүртгэнэ.
2. Төрийн тусгаарлан төлбөр, тусгай нийгмийн асуудлыг цахим системээр оруулна.
3. “Цахим дэлгүүрийн систем” нь “Ерөнхий гэрээ байгуулах журмын”-ын 2.2-т заасан аргудас ерөнхий гэрээнд тусгаарлан оруулна.

☐ Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрч байна

БАТАЛГААЖУУЛАХ

Зураг 17. Захиалга баталгаажуулах цонх

Захиалга амжилттай хийгдсэн тухай мэдэгдэл харуулна.




Зураг 18. Захиалга амжилттай

- **САНАЛ ХҮЛЭЭН АВАХ ОГНОО** - Ерөнхий гэрээний хоёр дахь шатны сонгон шалгаруулалтад нийлүүлэгчийн ирүүлэх үнийн саналыг хүлээн авах эцсийн хугацаа

АЛХАМ 3. ЗАХИАЛГЫН ЖАГСААЛТ ХАРАХ

Захиалагчийн эрхээр системд нэвтэрч **ЗАХИАЛГА – ЗАХИАЛГЫН ЖАГСААЛТ** цэсэд хандана.



Зураг 19. Захиалгын жагсаалт харах

- Захиалгын дугаар болон санал хүлээн авах огноогоор хайлт хийх боломжтой байна.
- Захиалгын дугаар, санал хүлээн авах хугацаа, захиалга хийгдсэн огноо, оролцогчдын барааны жагсаалтыг нийлүүлэгч байгууллагаар болон бараагаар ангилан харах зэрэг боломжтой байна.
- Шинээр нэмэгдсэн захиалгын жагсаалтаас тухайн захиалгын талбар дээр дарж захиалгын дэлгэрэнгүйг харна.
- Захиалгын дэлгэрэнгүй хэсгээс “Захиалга цуцлах” товч дээр дарж захиалгыг цуцлах боломжтой.

Төлөв: **Захиалга хийгдсэн**


Захиалга цуцлах

№	Оролцогчийн нэр	Шаардаж байгаа тоо	Ерөнхий гэрээний үнэ	Шинж чанар	Нийлүүлэх хугацаа
1	Тестийн Байгууллага ХХК	3	2200	Ааааа	2021-05-31
2	Тест Ххх Санлбар	3	2220	Ааааа	2021-05-31
3	Тестийн Нийлүүлэгч-Ажаргал ХХК	3	2200	Ааааа	2021-05-31

Зураг 20. Захиалга цуцлах


АЛХАМ 4. ИРҮҮЛСЭН САНАЛЫГ ХАРАХ

Системийн **ЗАХИАЛГА – ИРҮҮЛСЭН ЗАХИАЛГЫН ЖАГСААЛТ** цэсэд хандана.



Зураг 21. Ирүүлсэн саналууд харах

- Ирүүлсэн саналын жагсаалтаас санал харах гэж буй захиалгыг сонгоно.
- Захиалгын барааны жагсаалтаас Үнэ харах товч дээр дарж оролцогчдын ирүүлсэн санал болон шалгарсан эсэх мэдээлэл харна.



Зураг 22. Захиалгын санал цонх

- Захиалгад нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн үнийн саналыг нээсний дараа цахим систем хамгийн бага үнэ ирүүлсэн нийлүүлэгчийг шалгаруулж, захиалга нь **ЗАХИАЛГЫН ҮР ДҮН** цэс рүү шилжинэ.
- Захиалгын үнэ ирүүлээгүй нийлүүлэгч байгууллага нь тухайн захиалгаас хасагдах бөгөөд хэрэв нэг ч үнийн санал ирээгүй бол захиалгыг амжилтгүй болсон гэж үзэж дахин захиалга өгнө.
- Нийлүүлэгч нь “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын 10.3.2.-д “Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч хоёроос дээш удаа гэрээний үүргээ биелүүлээгүй болон гаргасан алдаа дутагдал давтагдсан бол;” гэж заасны дагуу ерөнхий гэрээг цуцалж, эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэнэ.
- Захиалгад оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг харахад адил үнэ болон хугацаа ирүүлсэн бол шалгарсан эсэх төлөвийн оронд “**Сонгох**” гэсэн товч харуулна. Захиалагч байгууллага тэнцүү саналтай оролцогчдын аль нэгийг сонгоход тус оролцогч “**ШАЛГАРСАН**” төлөвтэй болно.

АЛХАМ 5. ЗАХИАЛГЫН ҮР ДҮН ХАРАХ БА ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Системийн **ЗАХИАЛГА – ЗАХИАЛГЫН ҮР ДҮН** цэсэд хандана.

ЗАХИАЛГЫН ЖАГСААЛТ

Хяналтын санбар > Захиалгын жагсаалт

Хайлт

Захиалгын дугаар: Санал хүлээн авах огноо:

Хайх Цэвэрлэх

Захиалгын үр дүн

Захиалгын дугаар	Санал хүлээн авах хугацаа	Захиалга хийгдсэн хугацаа	Захиалгын үр дүн гарсан
1 ТЗБ/004	3	2021-05-16 19:10	2021-05-09

1 эс 1 харагдаж байна (Нийт: 1)

« 1 » 20

Зураг 23. Үр дүн гарсан захиалгын жагсаалт

1. Үр дүн гарсан захиалгын жагсаалтаас захиалга тус бүрийн талбар дээр дарж **ЗАХИАЛГЫН ҮР ДҮН** хэсэгт шилжинэ. Тус хэсэгт оролцогч болон бараагаар ангилан харах боломжтой байна. Шалгарсан байгууллагын талбар дахь “Гэрээ байгуулах” товч дээр дарснаар гэрээ байгуулах цонх харагдана.

Хяналтын санбар > Захиалгын жагсаалт > Захиалгын үр дүн

Захиалгын дугаар: ТЭБ/004 Захиалагчийн нэр: Төстийн Захиалагч - ББ Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага

Санал хүлээн авах эцсийн хугацаа: 2021-05-16 19:10 Захиалга хийсэн огноо: 2021-05-09

Төлөв: Захиалгын үр дүн гарсан

ЗАХИАЛГЫН БАРААНЫ ЖАГСААЛТ

№	Оролцогчийн нэр	Ерөнхий гэрээний үнэ	Тоо хэмжээ	Санал болгох хугацаа	Санал болгосон үнэ	Төлөв	Үйлдэл
TEST EM							
1.	Төстийн Байгууллага ХХК	2,200	3			Хасагдсан	
2.	Төстийн Нийлүүлэгч-Ажиргал ХХК	2,200	3			Хасагдсан	
3.	Төст ХХК Санбар	2,220	3	2021-05-24	2,100	Шалгарсан	Гэрээ байгуулах

Хуудас: < 1 > | Нийт хуудас: 1 | 20 | Нийт бичлэг: 3

Зураг 24. Захиалгын үр дүн цонх

2. Гэрээ байгуулах цонхны холбогдох талбаруудын утгыг бүрэн оруулсны дараа “Хадгалах” товчийг дарна.

Шалгарсан байгууллага: Төст ХХК Санбар

Захиалагч байгууллага: Төстийн захиалагч - ББ

Гэрээний дугаар: ТЭБ/004/001

Гэрээний нэр:

Гэрээ байгуулсан огноо:

Гэрээ эхлэх огноо:

Гэрээ дуусах огноо: 2021-05-31

Хавсралт Сав баглаа боодлын зааварчилгаа Гэрээний тусгай зөвшөөрөл

+ Нэмэх

Файлын нэр

ГЭРЭЭНИЙ БАРААНЫ ЖАГСААЛТ

№	Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Санал болгосон үнэ	Санал болгосон хугацаа
1.	Спирометрон	TEST EM	Хайрлаг	3	2,100	2021-05-24

Хуудас: < 1 > | Нийт хуудас: 1 | 20

Нийт дүн: 6,300

Зургаан мянга гурван зуу

Хадгалах Хадгалах-Харх Хазх

Зураг 25. Гэрээ байгуулах цонх

- **ГЭРЭЭНИЙ ДУГААР** – Систем автоматаар санал болгох ба захиалагч гараас засварлах боломжтой байна
- **ГЭРЭЭНИЙ НЭР** – Гэрээний нэрийг гараас оруулна
- **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ОГНОО** – Гэрээ байгуулсан огноог гараас оруулна
- **ГЭРЭЭ ЭХЛЭХ ЭХЛЭХ ОГНОО** – Гэрээ эхлэх огноог гараас оруулна
- **ГЭРЭЭ ДУУСАХ ОГНОО** – Гэрээ дуусах огноог гараас оруулна
- **ХАВСРАЛТ** – Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээний маягтын дагуу байгуулсан гэрээний pdf өргөтгөлтэй файлыг хавсаргана
- **САВ БАГЛАА БОДЛЫН ЗААВАРЧИЛГАА** болон **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ** гэсэн нэмэлт мэдээллүүдийг оруулаад “Хадгалах” товч дарснаар гэрээний жагсаалт руу нэмэгдэнэ

АЛХАМ 6. ГЭРЭЭ ХАРАХ БОЛОН ГЭРЭЭГ ХААХ

Системийн **ЗАХИАЛГА – ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ** цэсэд хандахад захиалгын гэрээний жагсаалт байрлана.

ЗАХИАЛГЫН ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ

Хангалтын самбар > Захиалгын гэрээний жагсаалт

Хайлт

Гэрээний дугаар: Гэрээ байгуулсан огноо:

Гэрээний нэр: Гэрээ байгуулсан огноо:

Хайлт Цэвэрлэх

Бараа нийлүүлэх гэрээний жагсаалт

	Гэрээний дугаар	Гэрээний нэр	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ байгуулсан хугацаа	Цэнэ
1	ТЗБ/003/001	Гэрээ-2	6,600	Тест Ххх Салбар	2021-05-16	Цэнэ
2	ТЗБ/004/001	Гэрээ - 1	6,300	Тест Ххх Салбар	2021-05-16	Цэнэ

1 үсэг 2 харагдаж байна (Нийт: 2)

« 1 » 20

Зураг 26. Захиалгын гэрээний жагсаалт

- Бараа нийлүүлэх гэрээний жагсаалтаас сонгож гэрээний дэлгэрэнгүй хэсэгт шилжинэ.
- Гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг харах тус шалгарсан байгууллагыг үнэлэх, сэтгэгдэл бичих, гэрээг pdf файл руу хөрвүүлж харах, Гэрээг хаах зэрэг үйлдлийг гүйцэтгэх боломжтой байна.

Асуулт, хариулт | Хэрэглэгчийн хөтөч | Тусламж

Б. Бэлгүтэй (tzb) | Тестийн захиалагч - ББ

ГЭРЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ

Ханалтын самбар > Захиалгын гэрээний жагсаалт > Гэрээний дэлгэрэнгүй

Гэрээний дугаар:	T36/003/001	Гэрээний нэр:	Гэрээ-2
Гэрээний дүн:	6,600	Гэрээ байгуулсан оролцогч:	Тест Ххи Самбар
Гэрээ байгуулсан огноо:	2021-05-16 00:00	Гэрээ эхлэх огноо:	2021-05-16
Гэрээ дуусах огноо:	2021-05-28	Төлөө:	Шинэ

Гэрээ PDF-р харих | Гэрээ жаах

ЗАХИАЛГЫН БАРААНЫ ЖАГСААЛТ

№	Барааны код	Барааны нэр	Хэмжээ нэгж	Тоо хэмжээ	Санал болгох үнэ	Санал болгох хугацаа	Үнэлгээ	Сэтгэгдэл	Үйлдэл
1.	Спиролактон	TEST EM	Хайрцаг	3	2,200	2021-05-24	★ ★ ★ ★ ★		Үнэлэх

Хуудас: < 1 > | Нийт хуудас: 20

Хавсралт

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

+ Нэмэх

Файлын нэр

Зураг 27. Гэрээний дэлгэрэнгүй

- Захиалагч эсвэл нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь ерөнхий гэрээний хоёр дахь шатны худалдах, худалдан авах гэрээг байгуулж, бараа, үйлчилгээг хүлээлцэнэ.
- Захиалагч өөрийн хэрэгцээ, шаардлагыг нарийн зөв тодорхойлж, захиалга хийх ёстойг анхаарна уу.



АГУУЛГА

Цахим системийн талаар	1
1. Ерөнхий гэрээ, цахим дэлгүүр	5
2. Ерөнхий гэрээ байгуулах журам	5
3. Цахим дэлгүүрийн систем дээр ажиллах дараалал	16
Алхам 1. Захиалга хийх	17
Алхам 2. Захиалга баталгаажуулах	21
Алхам 3. Захиалгын жагсаалт харах	22
Алхам 4. Ирүүлсэн саналыг харах	23
Алхам 5. Захиалгын үр дүн харах ба гэрээ байгуулах	24
Алхам 6. Гэрээ харах болон гэрээг хаах	26



ЭЭХХЗГ



ТХААГ



ДЭМБ